



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Шатарбалын РАДНААСЭД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.  
Утас: 26-45-25, Факс: 32-70-16  
E-mail: radnaased@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022. 01.07 № ЧУХ-03/200

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ш.РАДНААСЭД

С.БЯМБАЦОГТ

Б.ЭНХ-АМГАЛАН

Ш.АДЬШАА

000409



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Шатарбалын РАДНААСЭД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.  
Утас: 26-45-25, Факс: 32-70-16  
E-mail: radnaased@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2021.08.08 № УХХ-03/9017

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх

хугацааг товлох тухай

Миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох бүрдлийг ханганд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгээд байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ш.РАДНААСЭД



000406



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20<sup>21</sup> он 29 дугаар  
сарын 21-ны өдөр

Дугаар 135/2021

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ш.РАДНААСЭД ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт /.. хуудас.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



ЦНЯМДОРЖ

000021512944

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлд:

## "I.ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн санаачлан боловсруулсан Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлт

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монгол Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн санаачлан боловсруулсан Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хуулийн төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:


1.Хуулийн төсөлд зарим компани, барилга байгууламж зэрэгт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр заасан нь Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын "татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд шударга байх" зарчимд нийцэж байгаа эсэхийг нягтлах;

2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу зардлын тооцоо буюу албан татварын чөлөөлөлттэй холбоотой гарах зардал, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг хийгээгүй, түүнчлэн, үзэл баримтлалын төсөлд тусгасан "хуримтлагдсан татварын өр"-ийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдэл байхгүй байна.

Иймд холбогдох тооцоо, судалгааг гүйцэтгэж, бүрдүүлбэрийг хангах, судалгааны дүгнэлт, саналын дагуу хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахад анхаарах:

3.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-1.0 хувиар тооцож ногдуулна." гэж заажээ. Өөрөөр хэлбэл, хуулийн дээрх заалтын хүрээнд албан татварын хувь хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хуульд заасан хязгаарт багтаан тогтоохоор байна.


Иймд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулахгүйгээр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалтын хүрээнд татварын хөнгөлөлтийн асуудлыг зохицуулах боломжтойг анхаарах нь зүйтэй байна." тэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ:**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Ш. РАДНААСЭД**

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага.**

**1.1. Хууль зүйн үндэслэл.**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030)”-д Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар мөн гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.7-д “Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ” гэж тусгасан.

**1.2. Практик шаардлага.**

Эрчим хүчний төрийн өмчит компани нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон үнэ тарифаар борлуулдаг бөгөөд энэ нь үйлдвэрлэх, түгээх, дамжуулах, өргөөс бага байдаг тул төвөөс алслагдмал аймаг, сумыг цахилгаан эрчим хүчээр хангадаг цөөн тооны компанийд үнийн зөрүүг татаас хэлбэрээр улсын төсвөөс олгодог бөгөөд эдгээр компаниудад дараах хүндрэлтэй асуудал тулгарч байна.

Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15-д “төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшууллыг нэмэгдсэн өргтийн албан татвар ногдуулах үйл ажиллагаанд нэгэн адил хамруулна” гэж заасан нь тухайн хуулийн этгээдийн алдагдлыг нэмэгдүүлж, мөн хэмжээгээр хөрөнгө оруулалт санхүүжилт буурах нөхцлийг бүрдүүлж байна.

Эрчим хүчний төрийн өмчит компанийн усан цахилгаан станцын барилга, усны барилга байгууламж зэрэгт зарим орон нутгийн татварын байцаагч нар үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж байна. Энэ нь захиргааны хэргийн шүүхэд маргаан үүсгэж, улмаар анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдэж байна. Гэтэл зарим орон нутгийн татварын байцаагч нар Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө, 7.1.3-т нийтийн эзэмшилийн барилга байгууламж гэж заасныг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулдаггүй байна.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2 дахь заалтын дагуу хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл шаардлагад тулгуурлан зохицуулах дараах асуудлыг тусгана.

Үүнд: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эрчим хүчний төрийн өмчит компанийн усан цахилгаан станцын барилга, усны барилга байгууламж гэсэн заалтыг нэмэлтээр оруулна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, здийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал.**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газарт татварын харилцаанд үүсч байгаа хүндрэлтэй асуудал шийдвэрлэгдэнэ, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад дэмжлэг болно.

Улс орны здийн засгийн өсөлт, тогтвортой хөжил, эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангана.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

--- oOo ---

## ТАНИЛЦУУЛГА

*Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчин найдвартай, аюулгүй, тогтовортой байдлыг бүрэн хангах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах чиглэл тусгагдсан.

Монгол Улсын эрчим хүчиний салбар нь газар нутгийн алслагдмал байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамааран төв, зүүн, баруун болон Алтай-Улиастай эрчим хүчиний сүлжээ гэсэн дөрвөн хэсгээс бүрдэж байна.

Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчиний суурилагдсан хүчин чадлын хоёр хувийг усан цахилгаан станц үйлдвэрлэж байна. Эрчим хүчиний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компани нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон үнэ тарифаар олон нийтэд борлуулдаг бөгөөд энэ нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дамжуулах өртгөөс бага байдаг.

Мөн зарим орон нутгийн татварын байгууллагаас сэргээгдэх эрчим хүчиний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн цахилгаан станцын барилга, далан, ашиглалтын тунель, ажлын байр зэрэгт Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж байгаа нь хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангахын тулд үндсэн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай турбин, генераторын урсгал засваруудыг хийж үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахад хүндрэл бэрхшээл тулгарсаар байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15-д төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшууллыг нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах үйл ажиллагаанд нэгэн адил хамруулна гэж заасан нь тухайн хуулийн этгээдийн алдагдлыг нэмэгдүүлж, мөн хэмжээгээр хөрөнгө оруулалт санхүүжилт буурах, төдийгүй зээлийн буцаан төлөлтөд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж байна.

2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр <http://www.lawforum.parliament.mn> сайтад байршуулсан бөгөөд ямар нэгэн санал ирээгүй болно.

Хууль санаачлагч

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулагатай 7.1.6 дахь заалт нэмсүгэй:

“7.1.6.төрийн өмчит усан цахилгаан станцын барилга байгууламж.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

2021 он

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

**НЭГ. Ерөнхий мэдээлэл**

“Алтай Улиастайн Эрчим Хүчний Систем” ТӨХК, Тайшир сумын нутаг Завхан гол дээр баригдсан 11МВт-ын суурилагдсан хүчин чадалтай “Тайшир-Гуулин усан цахилгаан станц” /УЦС/ ХХК-ийн үйл ажиллагааг тус тус танилцуулав.

“Тайшир-Гуулин УЦС”-ыг Кувейт болон Абу Даби сангийн 42.8 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр 2004-2008 онд барьж ашиглалтад оруулсан. УЦС-ын далангийн өндөр 50м, хярын урт 192м бөгөөд даланг байгуулснаар 52.5 км<sup>2</sup> талбайтай, 1 тэрбум м3 эзлэхүүнтэй усан сан үүссэн. Жилд 30 сая орчим кВт.цаг эрчим хүч үйлдвэрлэж Говь-Алтай, Завхан аймгийн төв болон 24 сумыг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

**ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**Мөн чанар, цар хүрээг тогтоох**

Тайширын Усан цахилгаан станц Арабын Абу Даби болон Кувейтын Хөгжлийн сангийн нийт 42,6 тэрбум /тухайн үеийн ханшаар/ төгрөгийн зээлээр баригдсан бөгөөд одоогийн ханшаар Сангийн яаманд Үндэсний Аудитын газрын 2020 онд хийсэн шалгалтын тайланд дурдагдсанаар 91,5 тэрбум төгрөгийн зээлийн төлөлттэй холбоотой дамжуулан зээлэх гэрээ хийгдээгүй байна.

Энэхүү урт хугацаат зээлийг Тайширын Усан цахилгаан станц төлөхийн тулд 40 жилийн хугацаатай жилд 1 тэрбум төгрөгийг төлөхөд одоогийн цахилгаан эрчим хүчний өөрийн өртөгийг кВт.цаг тутамд 50-55 төгрөгөөг нэмэгдүүлж, хэрэглэгчийн тарифыг 45-50 хувиар нэмэгдүүлэх нөхцөл үүсэх юм.

Эрчим хүчний компанийд төрөөс олгон татаасыг нэмэгдүүлэхгүй, хэрэглэгчийн тарифыг нэмэгдүүлэхгүй байх шаардлагын улмаас Усан цахилгаан станцаас үйлдвэрлэн борлуулах эрчим хүчний үнийг 25-35 төгрөгөөр тогтоож байгаа учир урт хугацаат зээл, мөн богино хугацаат өр төлбөр буюу Үл хөдлөх хөрөнгийн татварыг төлөх боломж гарахгүй байгаа юм.

Монгол улсын Засгийн газраас Эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд татаасыг бууруулах, нөгөө талаас хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн хямд байлгах бодлого, зорилгыг хэрэгжүүлэн ажилладаг байгуулагын хувьд тарифт суусан татвар, хураамжийг тогтмол төлдөг бөгөөд орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэхээр Орон нутгийн татварын байгуулагын оногдуулсан татварыг төлөх эх үүсвэргүй байгаа юм.

Эрдэнэбүрэнгийн зэрэг Усан цахилгаан станц барьж ашиглах тохиолдолд хөрөнгө оруулагчид Засгийн газрын тогтоосон татвараас гадна орон нутгийн Татварын байгуулагын ногдуулсан татварыг давхар төлөх тохиолдолд хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа уртасч, хөрөнгө оруулагчийн сонирхол буурах, нөгөө талдаа үйлдвэрлэх бүтээгдэхүүний үнэ өндөр болж, эрчим хүчний салбарын алдагдал нэмэгдэх эрсдэлтэй байдал үүсэх юм.

Жишээлбэл Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцын далангийн барилга Тайшир УЦС-аас 2-2,5 дахин том, 100 орчим тэрбумын өртөгтэй байх бөгөөд өнөөгийн эрхзүйн байдлаар татвар ногдуулсанаар зөвхөн үл хөдлөх хөрөнгийн татварт жилд 1 тэрбум орчим төгрөг төлөх, Тайшираас Алтай хот руу татсан цэвэр усны шугам сүлжээ нь мөн татварт жилд 200 сая төгрөг төлөх гэхмэтчилэн ард иргэдэд борлуулах өртөг нэмэгдэх эсвэл улсын төсвийн татаас авах нөхцөлүүд үүсэх тул Үл хөдлөх хөрөнгийн татварын хуулийн 7-р зүйлд УЦС-ын усны барилга байгууламж, далан, тунель, ус хангамжийн төв шугам хоолой зэргийг үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөхөөр тусгах шаардлага тулгараад байна

### **Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл**

2012-2013 оны татварын зөрчилд 2014 оны 10-р сарын 21-нд Аймгийн татварын хэлтэсийн байцаагчийн 050008495 тоот актаар тогтоосон 83 сая төгрөгийн төлбөрийг төлөх үндэслэлгүй, төрийн өмчит, төрөөс хатуу тогтоосон үнээр эрчим хүчийг толгой компанийд худалдан, зөвхөн эрчим хүчний яам, сангийн яам, төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнтэй ТУЗ, эрчим хүчний зохицуулах хорооноос баталж өгсөн зардлыг санхүүжүүлэн үйл ажиллагаа явуулдаг тул Үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөгднө гэсэн үндэслэлээр шүүхийн 2 шатны шийдвэр гарч дээрх актыг хүчингүй болгосон.

2014, 2015 оны татварын үйл ажиллагаанд мөн шалгалт хийж, Аймгийн татварын хэлтэсийн улсын байцаагчийн 2016,10,03-ны 050021475 тоот актаар нийт 664 194 322,5 /зургаан зуун жаран дөрвөн сая нэг зуун ерөн дөрвөн мянга гурван зуун хорин хоёр/ төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги төлүүлэхээр шийдвэрлэсэн.

Говь-Алтай аймгийн анхан шатны шүүхээс манай гомдлыг хэрэгсэхгүй болгон татварын байцаагчийн актыг хүчингүй болгож шийдвэрлэсэн. Монгол улсын Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2017 оны 10-р сарын 03-нд Татварын байцаагчийн актыг хүчингүй болгосон шийдвэр гарсан боловч, Дээд шүүхэд Татварын байгууллага гомдол гаргаснаар 2017 оны 12-р сарын 13-нд татварын байцаагчийн актыг хүчинтэй болгон татварын алданги, торгуулийг хүчингүй болгон нөхөн татвар 420 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн.

2018 оны 07-р сарын 18-нд Шүүхийн шийдвэр гарч шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаас манай байгууллагад шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл ирсэн. Үл хөдлөх хөрөнгийн татварын өрийг төлөх тохиолдолд 2014-2018 оны 1092,0 сая төгрөгийн эх үүсвэр шаардагдахаар болж байна.

2012-2017 онд Тайшир УЦС-ын тариф 34,2-37,4 төгрөгөөр тогтоож байсан бол 2017 оноос чадлын тариф 31 сая төгрөг, энергийн тариф 1,74 төгрөг болон буурч тогтоогдсон.

Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөх тохиолдолд Тайшир УЦС-ын эрчим хүч үйлдвэрлэх тарифыг 12-15 төгрөгөөр нэмж, тэр хэмжээгээр "АУЭХС" ТӨХК-ийн алдагдал ихэсч, улсын төсвөөс олгодог татаасыг, нэмэгдүүлэх нөхцөлд болно.

Хэрэглэгчийн тарифыг хатуу тогтоосон, нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал өнөөгийн нөхцөлд манайд тавьсан актыг төлбөрийг нөгөө талаасаа татварын байгуулага өөрөө төсөв бүрдүүлдэгийн хувьд татаас хэлбэрээр "АУЭХС" ТӨХК-д

бүрдүүлэн өгөхөөс өөр аргагүй нөхцөл байдлыг татварын байгууллагын ойлгохгүй олон удаа шүүхэд хандан төрийн байгууллагууд бие биенийхээ ажилд саад тушаа болж байгаа нь бидний ажилд хүндрэл учруулж байна.

2019 онд Тайшир УЦС 33 сая кВт цаг цахилгаан үйлдвэрлэж, 886 сая төгрөгийн орлого олж, ажиллагсадын цалин НДШ-д 540 сая төгрөг, ус ашигласны татварт 42 сая, тогтмол зардалд /дулаан, цахилгаан, ус/ 41 сая, хөдөлмөр хамгаалал 49 сая, урсгал болон их засварт 70 сая, Гуулин УЦС-ын ашиглалт, сувгийн төлбөрт 25 сая төгрөгийг зарцуулж, хөрөнгө оруулалт, ажиллагсадын нийгмийн асуудалд төдийлөн хөрөнгө зарцуулах боломжгүй үйл ажиллагаа явуулж байна.

## **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулья.

“Тэг” хувилбар буюу зохицуулалт хийхээс татгалзах”- Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй тул төрөөс тодорхой зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.

“Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх”- тохиромжгүй хувилбар.

“Төрөөс санхүүгийн интервенц хийх”-тохиромжгүй хувилбар.

“Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” - тохиромжгүй хувилбар.

Сонгосон хувилбарын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны эерэг, сөрөг талыг харьцуулан судалвал:

Хүснэгт 1

| Зохицуулалтын хувилбар  | Зорилгод хүрэх байдал                                  | Зардал, үр өгөөжийн харьцаа  |
|---|--|--|
| 1.Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх |  | Зардал хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай адил гарна. Асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй хувилбар |
| 2.Хууль тогтоомжийн   | Хуулийн хэрэгжих боломжийг дээшлүүлэх, ус бохирдуулсны | Зардал гараг боловч энэ хувилбар нь  |

|                    |  |  |
|--------------------|--|--|
| төсөл боловсруулах | төлбөрийн орлогыг төвлөрүүлэх замаар ус, усан орчинг хамгаалах, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглахад чиглэсэн техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагаанд эдийн засгийн урамшууллын хөшүүргийг тодорхой болгох, аж ахуйн нэгжид үзүүлэх татварын дарамтыг бууруулах, давхардлыг арилгах, иргэн аж ахуйн нэгж болон хаягдал ус цэвэрлэх үүрэг хүлээсэн байгууллагуудын уялдааг сайжруулах. | асуудлыг шийдвэрлэхэд оновчтой хувилбар. |
|--------------------|--|--|

#### **ТАВ. СОНГОСОН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн хууль тус бүрээр гаргалаа.

**Жич:** Хүний эрх, Эдийн засаг, Нийгэм, Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгтээс үзнэ үү.

#### **5.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө**

Хүснэгт 2

| Үзүүлэх үр нөлөө  | Холбогдох асуултууд | Хариулт   |      |
|---|---------------------|---|------|
| <b>1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх</b>  |                     | <b>1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b> |      |
| 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх  |                     |   | Үгүй |
| 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх  |                     |   | Үгүй |
| 1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх |                     |   | Үгүй |
| <b>1.2. Оролцоог хангах</b>   |                     |   |      |
| 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх   |                     |   | Үгүй |
| 1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдэж буй, эсхүл хөндөгдэж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх                          |                     |   | Үгүй |
| <b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>  |                     |   |      |
| 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх   | Тийм                |   |      |

|  |   |      |      |
|--|---|------|------|
|  | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх                                     | Тийм |      |
|  | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх   |      | Үгүй |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх            | 2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх   |      | Үгүй |
|  | 2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх   |      | Үгүй |
| 3.Эрх агуулагч   | 3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх  | Тийм |      |
|  | 3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх  | Тийм |      |
|  | 3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх  | Тийм |      |
|  | 3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/ |      | Үгүй |
| 4.Үүрэг хүлээгч  | 4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх  | Тийм |      |
| 5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх   | Тийм |      |
|  | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бурдуулэх эсэх   |      | Үгүй |

## 5.2 Эдийн засгийн үр нөлөө

Хүснэгт 3

| Үзүүлэх үр нөлөө                        | Холбогдох асуултууд  | Хариулт |      |
|---|--|---------|------|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | Хуулийн төсөл нь дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?          |         | Үгүй |
|   | Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх үү? /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/?                   |         | Үгүй |
|   | Хуулийн төсөл нь дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах үү?                   | Тийм    |      |
|   | Хуулийн төсөл нь хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах үү?<br>Байгаль орчинд бохирдол учруулахуйц шийдвэр гаргахаас сэргийлнэ | Тийм    |      |

|  |   |      |      |
|--|---|------|------|
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | Хуулийн төсөл нь хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?   |      | Үгүй |
|  | Хуулийн төсөл нь зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?   |      | Үгүй |
|  | Хуулийн төсөл нь зах зээлд шинээр монополийг бий болгох уу?   |      | Үгүй |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал       | Хуулийг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжүүдэд тухайн хуулийг дагаж мөрдөхтэй холбогдон шинээр зардал үүсэх үү?  | Тийм |      |
|  | Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэрлэлийн үндсэн хүчин зүйлсийг /туүхий эд, тоног төхөөрөмж, эрчим хүч, ажиллах хүч/ гэх мэт хүчин зүйлс шинээр бий болгохыг шаардаж байгаа юу? | Тийм |      |
|  | Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх үү?  |      | Үгүй |
|  | Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх үү?   | Тийм |      |
|  | Ус цэвэршиулэх тоног төхөөрөмж, технологи гм.   |      |      |
|  | Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавьж байна уу?  |      | Үгүй |
|  | Тухайн зохицуулалт нь аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэж байна уу?  |      | Үгүй |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй захиргааны зардлын ачаалал  | Ижил тэнцүү нөхцөлд буй аж ахуйн нэгж, эсвэл бараа бүтээгдэхүүний хувьд харилцан адилгүй зохицуулалт бий болгож байна уу?   |      | Үгүй |
|  | Хуулийн төслөөр оролцогч этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг Жишээ нь, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт/ бий болгож байна уу?  | Тийм |      |
|  | Дээрх зардлын ачаалал нь ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүдэд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад хүчтэй нөлөөлөхөөр байна уу?  |      | Үгүй |
| 5.Өмчлөх эрх   | Хуулийн төсөлд / үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг/ өмчлөх эрхийг хөндсөн зохицуулалт байгаа юу?   |      | Үгүй |
|  | Тухайн зохицуулалтаар өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгож байна уу?   |      | Үгүй |
|  | Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг зөрчсөн зохицуулалт орсон уу?  |      | Үгүй |
| 6.Инноваци ба судалгаа шинжилгээ                               | Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг Хуулийн төслөөр дэмжиж байна уу?  | Тийм |      |

|                                 |   |      |      |
|---------------------------------|---|------|------|
|                                 | <p>Хуулийн төсөл нь үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгож байна уу?</p> <p>Нөөц боломжийг илүү үр дүнтэй ашиглахыг дэмжиж байна уу?</p>   | Тийм |      |
| 7.Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв | <p>Хуулийн төслөөр хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлж байгаа юу?</p> <p>Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгож байгаа юу?</p> <p>Хуулийн төсөл нь бараа, үйлчилгээний хангамж болон чанарт нөлөө үзүүлэх үү?<br/>Усны чанарыг сайжруулна гм</p> <p>Хуулийн төсөл нь хэрэглэгчийн эрх ашигт нөлөөлж байна уу?</p>   | Тийм | Үгүй |
|                                 | <p>Хуулийн төсөл нь хувь хүний гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид), эсвэл гэр бүл, үр хүүхдүүдийн эдийн засгийн баталгаатай байдалд нөлөө үзүүлэх үү?</p>  |      | Үгүй |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | <p>Хуулийн төсөл нь тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг шинээр бий болгох уу?</p> <p><i>Лабораторийн ажилтан зэрэг ажлын байр бий болгоно.</i></p> <p>Хуулийн төсөл нь тодорхой бүс нутгуудад тодорхой чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх үү?</p> <p><i>Цэвэрлэх байгууламж, ус ихээр бохирдуулдаг буюу ашигладаг үйлдвэрүүд технологио шинэчлэх шаардлагыг бий болгоно</i></p> | Тийм | Үгүй |
| 9.Төрийн захиргааны байгууллага | <p>Хуулийн төсөл нь улсын төсөвт нөлөө үзүүлэх үү?</p> <p>Хуулийн төслийн дагуу шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдаж байна уу?</p> <p>Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болж байна уу?</p>  | Тийм | Үгүй |
| 10.Микро засгийн хүрээнд        | <p>Хуулийн төсөл нь засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх үү?</p> <p>Хуулийн төсөл нь хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжиж байна уу?</p>   | Тийм | Үгүй |

|                        |   |  |      |
|------------------------|---|--|------|
|                        | Хуулийн төслийн зохицуулалтын улмаас инфляци нэмэгдэх үү?   |  | Үгүй |
| 11.Олон улсын харилцаа | Хуулийн төсөл нь Монгол Улсын худалдааны бодлого, түүнчлэн олон улсын болон ДХБ-ын эмнэ хүлээсэн үүрэгт сөрөг нөлөө үзүүлэх үү? |  | Үгүй |

### 5.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 4

| Үзүүлэх үр нөлөө                                    | Холбогдох асуултууд   | Хариулт |      |
|---|---|---------|------|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл      | Хуулийн төслийн үр дунд шинэ ажлын байр бий болох үү?   | Тийм    |      |
|   | Хуулийн төсөл нь ажлын байрны цомхотголыг шууд болон шууд бусаар бий болгох үү?   |         | Үгүй |
|   | Тодорхой нэг ажил мэргэжлийн хүмүүст, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх үү?  | Тийм    |      |
|   | Тодорхой насны хүмүүст, ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх үү?  |         | Үгүй |
|   | Ажиллах хүчин нэмж шаардах үү?  |         | Үгүй |
|   | Хөдөлмөрийн зах зээлд нөлөөлөх үү?  |         | Үгүй |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх                   | Ажлын чанар, стандартад нөлөөлөх үү? эзэрзэр  | Тийм    |      |
|   | Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх үү? эзэрзэр   | Тийм    |      |
|   | Ажилчдын эрх үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх?   | Тийм    |      |
|   | Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх?   |         | Үгүй |
|   | Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх?  | Тийм    |      |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал       | Хөдөлмөрийн зах зээлд ямар нэгэн өөрчлөлт орох үү?  | Тийм    |      |
|   | Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үзсэх үү?  |         | Үгүй |
|   | Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх үү? Жишээ нь ядуу хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд г.м     |         | Үгүй |
|   | Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх үү?   |         | Үгүй |
| 4.Хүйсийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх | Хуулийн төсөл нь ялгаварлан гадуурхахгүй байх, бүх хүнд ижил тэгш үйлчлэх, ижил боломж олгох зарчимтай нийцэж байна үү?                         | Тийм    |      |
|   | Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд ялгаатай нөлөөлөх үү?   |         | Үгүй |
|   | Хүйсийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлж чадах үү?  | Тийм    |      |
| 5.Хувь хүн, гэр бүл, тэдгээртэй                     | Хуулийн төсөл нь захиргааны нэмэлт үүрэг, хариуцлага бий болгож байна үү? Сав газрын захиргаад, МХЕГын ажилтнуудад хяналт хийх үүрэг нэмэгдэнэ. | Тийм    |      |
|   | Хувийн нууцад /гэр бүлийн болон харилцаа  |         | Үгүй |

|  |  |      |      |
|--|--|------|------|
| холбогдох мэдээлэл   | холбооны/ нөлөөлөх үү?   |      |      |
|  | Иргэдийн хувийн эрх, эрх чөлөөнд нөлөөлөх үү?  |      | Үгүй |
|  | Гэр бүлийн амьдрал, гэр бүлийн хууль, эдийн засаг, нийгмийн хамгаалалтад нөлөөлөх үү?  |      | Үгүй |
|  | Хүүхдийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх үү?   |      | Үгүй |
|  | Хувь хүний тухай мэдээлэл, түүнийг авахтай холбогдсон асуудалд нөлөөлөх үү?  |      | Үгүй |
| 6.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх үү?   |      | Үгүй |
|  | Харилцаанд оролцогчдод ижил тэгш байдлыг олгож байна уу?   | Тийм |      |
|  | Соёлын болон хэлний ялгааг бий болгох уу?  |      | Үгүй |
|  | Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх үү?   |      | Үгүй |
|  | Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх үү?   | Тийм |      |
|  | Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлэх эрхэд нөлөөлөх үү?   |      | Үгүй |
|  | Улс төрийн намууд, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх үү?  |      | Үгүй |
|  | Мэдээллийн эрх, эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрхэд сөрөг нөлөө үзүүлэх үү?  |      | Үгүй |
|  | Хувь хүний/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх үү?<br>Усны чанар сайжирснаар өвчлөлт буурах боломжтой | Тийм |      |
| 7.Нийтийн мэнд, аюулгүй эрүүл байдал   | Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөний улмаас эрүүл мэндэд гарах өөрчлөлт өсөх үү?   |      | Үгүй |
|  | Хуулийн төслийн улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үү?                  |      | Үгүй |
|  | Хуулийн тесел нь хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ/-т нөлөөлөх үү?                             |      | Үгүй |
|  | Нийгмийн тодорхой бүлэгт онцгойлон нөлөөлөх үү?  |      | Үгүй |
|  | Үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх үү?  | Тийм |      |
| 8.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем                             | <i>Ариутгах татуургын үйлчилгээ сайжирна</i>   |      |      |
|  | Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх үү?  |      | Үгүй |
|  | Иргэдийн боловсрол /терийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх үү?          |      | Үгүй |
|  | Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх үү?  |      | Үгүй |
|  | Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх үү?   |      | Үгүй |
|  | Зохицуулалт нь нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх үү?   | Тийм |      |
|  | <i>Урьдчилан сэргийлэх зерэг нөлөөтэй</i>  |      |      |

|                        |                |  |      |      |
|------------------------|----------------|--|------|------|
| 9.Гэмт нийгмийн байдал | хэрэг, аюулгүй | Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх үү?                     | Тийм |      |
|                        |                | Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх үү?                          | Тийм |      |
|                        |                | Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх үү? |      | Үгүй |
| 10.Соёл                |                | Соёлын өвийг хамгаалахад нөлөөлөх үү?                          |      | Үгүй |
|                        |                | Хэл соёлын ялгаатай байдалд нөлөөлөх үү?                       |      | Үгүй |
|                        |                | Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх үү?         |      | Үгүй |

#### 5.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 5

| Үзүүлэх үр нөлөө                           | Холбогдох асуултууд  | Хариулт          |      |
|--|--|------------------|------|
| 1.Агаар                                    | Хуулийн зохицуулалтын үр дүнд агаар бохирдлыг нэмэгдүүлэх үү?  |                  | Үгүй |
| 2.Зам тээвэр, түлш эрчим хүч               | Зохицуулалт нь тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх?<br>Эдийн засаг дахь эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх үү?<br>Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх үү? |                  | Үгүй |
| 3.Ан амьтан, ургамал хамгаалах             | Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх үү?<br>Ан амьтны тоо хэмжээг бууруулах уу?   |                  | Үгүй |
|  | Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх үү?  |                  | Үгүй |
|  | Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх үү?  |                  | Үгүй |
|  | Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх үү?   |                  | Үгүй |
| 4.Усны нөөц                                | Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцэд сэргээр нөлөөлөх үү?<br>Усны бохирдлыг нэмэгдүүлэх үү?   |                  | Үгүй |
|  | Үндны усны чанарт нөлөөлөх үү?   | Тийм<br>зэрэгээр |      |
| 5.Хөрсний бохирдол                         | Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх үү?<br>Зохицуулалт нь хөрсийг эвдлэх, ашигласан талбайн хэмжээг нэмэгдүүлэх үү?  | Тийм<br>Эзэрзэр  |      |
| 6.Газрын ашиглалт                          | Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах уу?<br>Газрын зохицуулалтыг өөрчлөх үү?<br>Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх үү?   |                  | Үгүй |
| 7.Нөхөн сэргээгдэх/<br>нөхөн сэргээгдэхгүй | Самар, жимс зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг түүний нөхөн сэргээлтийн хугацаанаас өмнө ашиглах уу?  |                  | Үгүй |

|        |  |  |      |
|--------|--|--|------|
| баялаг | Нөхөн сэргээгдээгүй газрыг нөхөн сэргээх үү? |  | Үгүй |
|--------|--|--|------|

## ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл.
4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2021 он.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
6. Төсвийн тухай хууль;
7. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт.

**ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**  
(Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай  
хуульд нэмэлт оруулах төсөл)

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь “хуульд нэмэлт оруулах” хэлбэрээр боловсруулагдсан.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>2</sup>-д/цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлгээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ  
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д<sup>3</sup> заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа зэрэг болно.

**Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

➤ **Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг

<sup>1</sup>Терийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолын 3 дугаар хавсралт.

<sup>3</sup> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Ойлгомжтой байдал:**

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дунд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томьёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд<sup>4</sup> заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг<sup>5</sup> хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал, практикт хэрэгжих боломж болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:**

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэд, байгууллага хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төслөөр иргэд, аж ахуйн нэгжид шинээр ямар нэгэн чиг үүргийг шинээр нэмж хүлээлгэхгүй тул “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан.

---

<sup>4</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

<sup>5</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “практикт хэрэгжих боломж” болон “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

## ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараахь байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

| Д/д | Шалгуур үзүүлэлт      | Үр нөлөөг үнэлэх хэсэг                            | Шалгах хэрэгсэл  |
|-----|-----------------------|---|--|
| 1   | Зорилгод хүрэх байдал | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.  |
| 2   | Ойлгомжтой байдал     | Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн тесэл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.        |
| 3   | Харилцан уялдаа       | Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.3, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах. |

### 1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн тесэл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгөд албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төлөх, тавараас чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл хуулийн тесэл нь төрийн өөрийн өмчийн хөрөнгөнө, үйл ажиллагааны орлогоос төр татвар авах асуудлыг зохицуулах зорилготой байна гэж тодорхойлж болохоор байна.

### 2.Ойлгомжтой эсэх:

## **“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд :**

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2-д зааснаар “хуульд нэмэлт оруулах” хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн, 2 зүйтэй, хуулийн төслийн бүтэц, дугаарлалт нь хуульд заасан болон “Хуулийн төсөл боловсруулах”<sup>6</sup> аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар хуулийн хуульд оруулах өөрчлөлтийг зөвхөн нэг хуульд хамааруулж хийх бөгөөд өөрчлөлт орж байгаа хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтын дугаарыг толорхой бичнэ гэсэн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд уг шаардлагад хэсэгтэй нийцэж байна.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна” гэсэн шаардлагыг хангаж Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

### **3.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:**

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.3, 29.1.5, 29.1.10-т заасан болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- **Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:**

| д/д | Шалгах асуулт  | Шаардлагыг хангасан эсэх  |
|-----|--|---|
| 1   | 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын опон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх; | Хангасан  |
| 2   | 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;  | Хуулийн төслөөр тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байна.   |
| 3   | 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;  | Хуулийн төслийн агуулга зохицуулалтаас үзэхэд хуулийн зорилго, зорилттой нийцсэн байх бөгөөд тухайн хуулиар зохицуулах харилцаанаас өөр зохицуулалт тусгагдаагүй байна. |
| 4   | 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;   | Хоорондоо зөрчилгүй байна.  |

<sup>6</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

|   |  |   |
|---|--|---|
| 5 | 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх; | Tус хуулийн төслийг дагаж бусад хуульд өөрчлөлт орхогхуй. |
|---|--|---|

○ Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

| Д/д | Асуулт  | Хариулт | Дүн шинжилгээ   |
|-----|---|---------|---|
| 1   | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;  | Тийм    | Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн үзэл баримтлал, хуулийн зорилтыг бүрэн хангасан байна.   |
| 2   | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;   | Үгүй    | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.  |
| 3   | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;  | Тийм    | Бүрэн тусгасан.   |
| 4   | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;  | Тийм    | Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй.   |
| 5   | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;   | Үгүй    |   |
| 6   | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Үгүй    | Хуулийн төсөлд иргэдийн эрхийг хязгаарласан ямар нэгэн нэмэлт зохицуулалт тусгадаагүй байна.  |
| 7   | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;   | -       | Хуулийн төсөлд энэ талаар тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд уг асуудлыг Жендерэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой. |
| 8   | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;  | -       | Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.                                   |

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа боловч үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгэхээр байна.

Иймд хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зохицуулалтыг өөрчлөх, зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Жич:Зохицуулалтыг боловсронгуй болгох, нэмэлт оруулах талаар Зөвлөмж хэсгээс дэлгэрүүлж харна уу.

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хийлээ. Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлтийг хийж, Зөвлөмж боловсрууллаа:**

### **Дүгнэлт:**

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг бүрэн хангахаж байна.
- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд хангасан байна.
- **Харилцан уялдааг хангасан байдал:** Байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгэхгүй бөгөөд харилцан уялдааг хангасан байна.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл.
4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2021 он.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
6. Төсвийн тухай хууль;
7. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт.

# **ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**/ ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

**УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН**

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх-/д заасны дагуу тооцлоо.

Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төсөлтэй танилцаад иргэн, хуулийн этгээдэд хамаарах зохицуулалтын хүрээнд хүсэлт гаргасан тохиолдлыг тооцоолов. Харин хуулийн төслийн зохицуулалт нь аргачлалд заасны дагуу мэдээлэх үүргийг шууд үүсгээгүй байгааг дурдах нь зүйтэй байна.

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР  
ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТУХАЙ**

Иргэнд үүсэх зардлыг дараах үе шаттайгаар тооцон үзлээ.

- 1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- 2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- 3.Тоон үзүүлэлтийг тооцох
- 4.Нийт дүнг тооцож гаргах
- 5.Хялбарчлах боломжийг шалгах

**1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох**

Хууль санаачлагч Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл буюу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтад төрийн өмчит усан цахилгаан станцын барилга байгууламжийг нэмж тусгахаар заасан байх бөгөөд үүнтэй холбоотой иргэнд аливаа үүрэг бий болохгүй байна.

**2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан иргэнд аливаа үүрэг ирэхгүй тул цаг хугацааны болон зардлын асуудал хөндөгдэхгүй байна.

**3.Тоон үзүүлэлтийг тооцож гаргах:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан иргэнд аливаа үүрэг ирэхгүй тул тоон үзүүлэлтийг тохиолдлын тоо буюу уг үүргийг хэдэн иргэн гүйцэтгэх ёстойг тооцоолох шаардлагагүй байна.

#### **4. Нийт дүнг тооцоолж гаргах:**

Энэ шатанд хуулийн төслийн хүрээнд импортлогч иргэнд шинээр бий болсон үргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тэдэнд үүсэх ачааллыг цаг хугацаагаар тооцоолон гаргах ёстой бөгөөд иргэнд аливаа ачаалал ирэхгүй юм.

#### **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТУХАЙ**

- 1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- 2.Зардлыг тооцох

#### **1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:**

Хуулийн төсөлд зааснаар иргэн, хуулийн этгээдэд хамаарах заалтын хувьд адилхан байна.

Хүснэгт 1

| <b>№</b> | <b>Хуулийн төслийн заалт</b>                                    | <b>Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг</b> | <b>Мэдээллийн агуулга</b> |
|----------|---|--|---------------------------|
| 1        | “7.1.6.төрийн өмчит усан цахилгаан станцын барилга байгууламж.” | ---                                      | ---                       |

#### **2.Зардлыг тооцох:**

Хуулийн этгээдэд аливаа нэмэлт зардал гарахгүй болно.

#### **ДӨРӨВ.ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТУХАЙ**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулагатай 7.1.6 дахь заалт нэмсүгэй:

“7.1.6.төрийн өмчит усан цахилгаан станцын барилга байгууламж.”

Гэж нэмэх нэг заалттай хуулийн төсөл байх бөгөөд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлээгүй тул хуулийн төсөл батлагдсанаар төрийн аль нэг байгууллага орон тоо нэмэх болон бусад зардал нэмэгдэхээргүй байна.